

**ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ТЭТГЭВЭР,
ТЭТГЭМЖИЙН ХЭЛТЭС А.ОКТЯБРЬ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.							
1.1. Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах.							
1.1.1	Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой тэтгэвэр, тэтгэмж тогтоох, олгох талаар шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах.	Шаард - лагагүй	Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2024 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.	Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна.	Засгийн газрын 221-р тогтоолоор 2025 оны 1-р сарын 1-ний өдрөөс өндөр нас, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, тусгай зохицуулалтын тэтгэврүүдийг 6%-аар нэмэгдүүлэн олгож ажилласан. 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 450 дугаар тогтоол "Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичиг, тэтгэвэр олгох" журмыг баримталж, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 231 дүгээр тогтоолыг мөрдөж тогтоосон итгэлцүүр, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон дээд хэмжээг шинэчлэн батлагдсан тогтоолын дагуу шинэ тэтгэвэр тогтоохдоо ашиглан хэрэгжүүлж байна. Нийгмийн даатгалын сангаас тэтгэмж тогтоох, олгох талаар шинээр батлагдсан "Даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгох журам", "ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт тэтгэвэр тэтгэмж олгох журам", "Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам", "Тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих журам" 2025.01.07 01/47 НДЕГ Зөвлөмж	100

						хүргүүлэх тухай зэрэг тэтгэмжтэй холбоотой дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.	
1.1.2	Ажил олгогч, иргэн, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн талаар зөвлөгөө, мэдээлэл сургалт зохион байгуулах		Зөвлөгөө мэдээлэл хүргэсэн ажил олгогч, даатгуулагчийн тоо Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо	Ажил олгогч, иргэн, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид	Ажил олгогч, иргэн, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчидийн нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээлэл дээшилсэн байна.	Хэрлэн сумын төсөв болон аж ахуйн нэгж байгууллагын 75 нягтлан бодогч нарт нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмж, төлбөр зардал эмнэлгийн хуудас илгээх талаарх сургалт, Сумдын эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнд 70 хүнд сургалт, Нэгдсэн эмнэлгийн 26 эмч ажилчдад, 2 аж ахуйн нэгжийн 56 албан журмын даатгуулагчдад нийгмийн даатгалын талаарх хууль тогтоомжийн сургалт, мэдээллийг тус тус хүргэж ажилласан байна. Хэнтий мэдээ сонинтой хамтран иргэд даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмжийн талаарх мэдээллийг Live хэлбэрээр 2 удаа мэдээлэл хүргэж ажилласан.	70

Биелэлт 170/2 85%

Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт

2. 1.Нийгмийн даатгалын тухай багц хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тэтгэврийг хуулиар тогтоосон хугацаанд тогтоох, олгох, хяналт тавих, тайлагнах;

2.1.1	Нийгмийн даатгалын сангаас олгох болон цэргийн тэтгэврийн баримт бичиг хүлээн авах, тэтгэврийн хувийн хэрэг нээж, дугаар өгөх, тэтгэвэр тогтоолгохоор бүрдүүлсэн баримтыг мэдээллийн санд бүртгэх, түүнд олгох сарын тэтгэврийн хэмжээг тогтоох, олгох; Иргэн, даатгуулагчийн тэтгэвэр тогтоолтын хуудсыг хэвлэж, хувийн хэрэгт хавсаргах,		Хувийн хэрэг нээж, бүртгэж дугаар өгсөн байна Тэтгэврийг хуулийн дагуу тогтоож, олгосон байна. Хувийн хэрэгт баримтыг бүрдлийн дагуу хавсаргасан байна		Нийгмийн даатгалын сангаас олгох болон цэргийн тэтгэврийн баримт бичиг хүлээн авч, тэтгэврийн хувийн хэрэг нээж, дугаар өгч, тэтгэвэр тогтоолгохоор бүрдүүлсэн баримтыг мэдээллийн санд бүртгэж, түүнд олгох сарын тэтгэврийн хэмжээг тогтоож, олгож; Иргэн, даатгуулагчийн тэтгэвэр тогтоолтын	Тайлант хугацаанд шинээр 399 тэтгэвэр тогтоолгох хүсэлт хүлээн авч тэтгэврийн хувийн хэрэг нээж, дугаар өгч тэтгэвэр тогтоолгохоор бүрдүүлсэн баримт материалыг скайнардад мэдээллийн санд оруулж, сарын тэтгэврийн хэмжээг тогтоож, олгох асуудлыг хуулийн дагуу хугацаанд нь шийдвэрлэн даатгуулагчийн тэтгэврийн тогтоолтын хуудсыг хэвлэж, баталгаажуулан хувийн хэрэгт хавсарган ажилласан. Үүнээс: өндөр нас 215, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 19, тэтгэврийн тусгай зохицуулалт 45, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	85
-------	--	--	--	--	---	--	----

					хуудсыг хэвлэж, хувийн хэрэгт хавсаргасан байна.	104, цэргийн тэтгэвэр 9, үйлдвэрийн ослын хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр 7 байна. Сар бүр тэтгэвэр олгосны дараа өдөр тэтгэврийн файлыг сумын байцаагчдад хүргүүлэн сар бүр тэтгэвэр олголтыг тулган шалгах ажил хийж байна. Эхний хагас жилийн байдлаар 9 хүнтэй холбоотой 9,6 сая төгрөгийн илүү олгосон тэтгэврийг улсын байцаагчийн мэдэгдэлээр тэтгэврийн санд буцаан татан авсан.	
2.1.2	Сар бүрийн тэтгэвэр олголтыг цахим хэлбэрээр бэлтгэж, банкинд хүргүүлэх; Нийгмийн даатгалын байгууллага болон банк нь тэтгэврийг сар бүрийн 01-ний өдөр олгох арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх		Тэтгэврийн олголтын цахим мэдээллийг бэлтгэж холбогдох байгууллагад хүргүүлж тэтгэврийг сар бүрийн 01-нд олгосон байна.		Сар бүрийн тэтгэвэр олголтыг цахим хэлбэрээр бэлтгэж, банкинд хүргүүлэн Нийгмийн даатгалын байгууллага болон банк нь тэтгэврийг сар бүрийн 01-ний өдөр олгох арга хэмжээг хамтран хэрэгжүүлж ажилласан байна.	2025 онд 2-р улирлын байдлаар 14398 даатгуулагчдад 63090,6 сая төгрөгийн тэтгэвэр олгоод байна. Сар бүрийн 25-нд сумдын байцаагчдаас тэтгэврийн хөдөлгөөний мэдээ авч мэдээллийн баазад оруулж тэтгэвэр олгох өдрийн өмнөх өдөр нь тэтгэвэр олголтыг бэлтгэн баталгаажуулж хамтран ажиллах гэрээ байгуулсан арилжааны 3 банкаар дамжуулан сар бүрийн 01-нд тэтгэврийг олгож хэвшсэн .	100
2.1.3	Тэтгэвэр авагчдын хувийн хэргийн шилжилт хөдөлгөөнийг тухай бүр бүртгэж, мэдээллийн санд оруулах, мэдээллийн сангийн бүртгэлтэй тулгах, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилт хийх;		Тэтгэврийн шилжилт хөдөлгөөн хийгдэж, мэдээллийн санд орсон байна.		Тэтгэвэр авагчдын хувийн хэргийн шилжилт хөдөлгөөнийг тухай бүр бүртгэж, мэдээллийн санд оруулан, мэдээллийн сангийн бүртгэлтэй тулгаж, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилт хийсэн байна.	Тэтгэвэр авагчдаас шилжиж хөдөлгөөн хийгдсэн нийт 23 тэтгэвэр авагч байна. Үүнээс бусад аймаг, сум, дүүргээс шилжиж ирсэн 3, бусад аймаг, сум, дүүрэг рүү шилжин явсан 11, аймаг дотор шилжих хөдөлгөөн хийгдсэн 9 тэтгэвэр авагчын мэдээллийн баазын бүрдлийг ханган ажилласан байна.	100
2.1.4	Нас барсан тэтгэвэр авагчдын хөдөлгөөнийг тухай бүр бүртгэж, мэдээллийн санд оруулах, мэдээллийн сангийн бүртгэлтэй тулгах, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилтад хяналт тавьж, хадгаламжийн нэгж үүсгэн		Мэдээллийн санд бүртгэл хийгдэж архивт хүлээлгэн өгсөн байна.		Нас барсан тэтгэвэр авагчдын хөдөлгөөнийг тухай бүр бүртгэж, мэдээллийн санд оруулах, мэдээллийн сангийн бүртгэлтэй тулгах, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилтад хяналт тавьж, хадгаламжийн	Нас барсан, зогсоогдсон тэтгэвэр авагчдын хөдөлгөөнийг тухай бүр бүртгэж, мэдээллийн санд оруулж, мэдээллийн сангийн бүртгэлтэй тулгаж, хадгаламжийн нэгж үүсгэн архивт хадгалуулах ажлыг зохион байгуулан 2024 онд нас барсан, зогсоогдсон 401 тэтгэвэр авагчын хувийн хэргийг архивт хүлээлгэн өгч ажилласан. 2025 оны 2-р улиралын байдлаар	100

	архивт хадгалуулах;				нэгж үүсгэн архивт хадгалуулах ажлыг зохион байгуулсан байна.	тэтгэвэр авах эрх зүйн харилцаа дуусгавар болсон нийт 160 тэтгэвэр авагчийн тэтгэвэр олголтын тооцоог хийв. Үүнээс нас барсан 132 зогсоогдсон 28 тэтгэвэр байна.	
2.1.5	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирсэн тогтоолын дагуу тэтгэвэр авагчийн тэтгэврээс суутгал хийх болон суутгал зогсоох тухай мэдэгдлийг мэдээллийн санд оруулж бүртгэх, холбогдох суутгалыг хийж, бүртгэл үйлдэн сангийн нягтлан бодогчид хүргүүлэх;		Суутгалыг холбогдох журам, зааврын дагуу хийж бүртгэл хөтөлсөн байна.		Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирсэн тогтоолын дагуу тэтгэвэр авагчийн тэтгэврээс суутгал хийх болон суутгал зогсоох тухай мэдэгдлийг мэдээллийн санд оруулж бүртгэх, холбогдох суутгалыг хийж, бүртгэл үйлдэн сангийн нягтлан бодогчид хүргүүлэн тооцоо нийлсэн байна.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирсэн тогтоолын дагуу 15 тэтгэвэр авагчийн тэтгэврээс 5,7 сая төгрөгийн тэтгэвэр суутган жагсаалтыг үйлдэн сан хариуцсан нягтлан бодогчид хүлээлгэн өгч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлэн ажилласан бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас ирүүлсэн албан бичгийг үндэслэн 2 тэтгэвэр авагчийн суутгалыг зогсоогоод байна.	90
2.1.6	Тэтгэврийн нэгдсэн хяналтыг сар бүр хийн бүртгэлээр хяналт тавьж, тайлан тэнцэл, мэдээ судалгааг гаргах, тайлагнах		Тэтгэврийн нэгдсэн хяналт, тайлан, мэдээ судалгааг үнэн зөв гаргах		Тэтгэврийн нэгдсэн хяналтыг сар бүр хийн бүртгэлээр хяналт тавьж, тайлан тэнцэл, мэдээ судалгааг хугацаанд нь үнэн зөв гарган тайлагнасан байна.	Сар бүр тэтгэвэр олгосны дараа өдөр тэтгэврийн файлыг сумын байцаагчдад хүргүүлэн сар бүрийн тэтгэвэр олголтыг тулган шалгах ажил хийж байна. Эхний хагас жилийн байдлаар 9 хүнтэй холбоотой 9,6 сая төгрөгийн илүү олгосон тэтгэврийг улсын байцаагчийн мэдэгдэлээр тэтгэврийн санд буцаан татан авсан. 2024 оны тэтгэврийн даатгалын сангийн тайланг гарган сан хариуцсан нягтлан бодогчид хүлээлгэн өгсөн.	70
2.2.Нийгмийн даатгалын тухай багц хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тэтгэмжийг хуулиар тогтоосон хугацаанд тогтоох, олгох, хяналт тавих, тайлагнах;							
2.2.1	Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны цаасан болон цахим эмнэлгийн хуудсаар бүртгүүлсэн тэтгэмжийг тогтоох;		Тэтгэмж үнэн зөв тогтоогдсон байна.		Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны цаасан болон цахим эмнэлгийн хуудсаар	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд заасан нөхцөл хангасан даатгуулагчид тэтгэмж тогтоон олгож, эрүүл мэндийн байгууллагаас цахимаар бичиж илгээсэн эмнэлгийн хуудсыг ажил олгогч, даатгуулагч хүлээн авч тэтгэмж	

					бүртгүүлсэн тэтгэмжийг тогтоох ажлыг өдөр тутам зохион байгуулан ажилласан байна.	авах хүсэлтээ эмнэлгийн хуудас авснаас хойш 4 долоо хоногийн дотор баталгаажуулж нийгмийн даатгалын байгууллагад илгээснээр магадлагч эмч, тэтгэмжийн байцаагч, хяналтын байцаагчаар баталгаажуулан Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 438 дугаар тогтоол Даатгуулагчийн тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгох журмын дагуу баримт бичгийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэж, ажил олгогч, даатгуулагчийн банкин дахь дансаар дамжуулан олголтыг хийж байна. Тэтгэмжийн даатгалын сангаас 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 989 даатгуулагчдад 2383,4 сая төгрөг олгосон үүнээс хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 652 даатгуулагчид 402,3 сая төгрөг, жирэмсэн болон амаржсаны тэтгэмж 337 даатгуулагчид 1981,0 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон байна	100
2.2.2	Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг бүртгэсэн баримт бичигт үндэслэн тогтоолт хийх;		Тэтгэмж үнэн зөв тогтоогдсон байна.		Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг бүртгэсэн баримт бичигт үндэслэн тогтоолт хийсэн байна.	Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг Даатгуулагчийн тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгох журмын дагуу цаасаар хүлээн авч sicos системд бүртгэл үүсгэж, хяналтын байцаагчаар баталгаажуулж тэтгэмжийг хуулийн хугацаанд буюу 24 цагийн дотор олгож байна тус сангаас 149 хүнд 298.0 сая төгрөгийн тэтгэмжийг олгосон байна.	90
2.2.3	Ажилгүйдлийн тэтгэмж авахаар бүртгүүлсэн даатгуулагчийн баримт бичигт үндэслэн тэтгэмжийн тогтоолт хийх;		Тэтгэмж үнэн зөв тогтоогдсон байна.		Ажилгүйдлийн тэтгэмж авахаар бүртгүүлсэн даатгуулагчийн баримт бичигт үндэслэн тэтгэмжийн тогтоолт хийж ажилласан байна.	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 438 дугаар тогтоол "Даатгуулагчийн тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгох журмын дагуу Ажилгүйдлийн тэтгэмжийг цаасаар болон цахимаар ажил олгогчийн	

					тушаал шийдвэр гарснаас хойш 28 хоногийн дотор цахимаар ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч даатгуулагчийн баримт бичигт үндэслэн тэтгэмж олгох, тогтоох тэтгэмж олгох даатгуулагчийн жагсаалтыг хяналт шалгалтын байцаагчаар хянуулан харьяалах нэгж хэлтэс, газрын даргаар баталгаажуулан тэтгэмж олгох жагсаалтыг сангийн нягтлан бодогчид хүргүүлж олголт хийж даатгуулагчид олгосон тэтгэмжийг ажилгүйдлийн тэтгэмжийн хувийн хэрэгт тэмдэглэгээ хийж байна. ажилгүйдлийн даатгалын сангаас 391 даатгуулагчдад 1303.7 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна.	90
2.2.4	Ажилгүйдлийн тэтгэмж авч буй даатгуулагчид илүү, эсхүл дутуу олгосон, ажилд орсон эсэхийг мэдээллийн санд үндэслэн тогтмол хяналт тавьж, үндэслэлгүй авсан тэтгэмжийг буцаан төлүүлэх арга хэмжээг тухай бүр авч тооцоолол хийх;		Үндэслэлгүй олгогдсон тэтгэмжийг хугацаанд нь бүрэн барагдуулсан байна.		Ажилгүйдлийн тэтгэмж авч буй даатгуулагчид илүү, эсхүл дутуу олгосон, ажилд орсон эсэхийг мэдээллийн санд үндэслэн тогтмол хяналт тавьж, үндэслэлгүй авсан тэтгэмжийг буцаан төлүүлэх арга хэмжээг тухай бүр авч тооцоолол хийн төлүүлэх арга хэмжээ авч ажилласан байна.	80
2.2.5	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг тооцох, олгох,		Тэтгэмж үнэн зөв тогтоогдсон байна.		Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг тооцож, олгон ажиллана.	100

2.2.6	Рашаан сувилалын болон сэргээн засах зардал, протез, ортопедын зардлын төлбөрийг тооцох, олгох		Тэтгэмж үнэн зөв тогтоогдсон байна.		Рашаан сувилалын болон сэргээн засах зардал, протез, ортопедын зардлын төлбөрийг үнэн зөв тооцон, олгож ажилласан байна.	ҮОМШӨ-ний даатгалын сангаас 7 хүнд 0.47 сая төгрөгийн сувилалын болон унааны зардлыг Засгийн газрын 2023 оны 11 дугаар сарын 29-ний өдрийн 422 дугаар тогтоолын зардалын төлбөр авахад бүрдүүлэх баримт бичгийн дагуу материалыг 28 хоногийн дотор хүлээн авч магадлагч эмчээр баталгаажуулан олгосон. Үйлдвэрлэлийн ослын сэргээн засах сувиллын тусламж үйлчилгээний болон протез, ортопедийн зардал төлбөр гараагүй болно.	100
2.2.7	Хугацаа дуусаж, зогсоогдсон ажилгүйдлийн тэтгэмжийн хувийн хэргийг архивын нэгж болгон архивд хүлээлгэж өгөх;		Баримт бичгийг архивд хүлээлгэн өгсөн байна.		Хугацаа дуусаж, зогсоогдсон ажилгүйдлийн тэтгэмжийн хувийн хэргийг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгсөн байна.	Ажилгүйдлийн даатгалын сангийн 2024 оны ажилгүйдлийн тэтгэмжийн хугацаа дуусаж, зогсоогдсон хувийн хэргийг 6 боть архивын нэгж болгон бүрдүүлэн газрын архивт хүлээлгэн өгсөн.	90
2.2.8	Тэтгэмжийн даатгалын сангийн тайлан, мэдээ судалгааг тухай бүр гаргах тайлагнах		Тайлан, мэдээ, судалгааг хугацаанд нь чанартай гаргасан байна.		Тэтгэмжийн даатгалын сангийн тайлан, мэдээ судалгааг тухай бүр гаргаж тайланг хугацаанд нь Санхүү бүртгэлийн тасагт хүлээлгэн өгсөн байна.	Тэтгэмжийн даатгалын сангийн тайланг тогтоосон хугацаанд нь үнэн зөв сicos программаар гаргасан. 1551 хүний тэтгэмжийн материалыг цахимаар болон цаасаар хүлээн авч эрх үүсэхгүй болон засуулах шаардлагатай 197 тэтгэмжийг буцаасан төлөвт шилжүүлж тэтгэмжийн эрхийн харилцаа үүссэн тэтгэмжийг хуулийн хугацаанд тогтоолт хийж хяналтын байцаагчаар баталгаажуулан олголт хийсэн. НДЕГазраас ирүүлсэн хугацаатай мэдээ судалгааг цаг хугацаанд нь хүргүүлсэн	100
2.2.9	Илүү, эсхүл дутуу олгосон тэтгэмж, төлбөрийн тооцооллыг хийж зөрүүг хуулийн дагуу олгох, эсхүл санд төлүүлэх ажлыг зохион байгуулах;		Зөрчил бүрэн арилсан байна		Илүү, эсхүл дутуу олгосон тэтгэмж, төлбөрийн тооцооллыг хийж зөрүүг хуулийн дагуу олгох, эсхүл санд төлүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж зөрчлийг арилгасан байна.	Ажилгүйдлийн даатгалын санд Улсын байцаагчийн актаар 6.3 сая төгрөгийн акт тавигдсанаас 3.6 сая төгрөг буюу 57 хувь барагдсан байна. Тэтгэмжийн даатгалын санд тавигдсан улсын байцаагчийн 6 даатгуулагчтай холбоотой 1.8 сая төгрөгийг 100 хувь барагдуулсан. НДЕГазрын хяналт шалгалтын газраас ажилгүйдлийн	80

						тэтгэмжид 8 даатгуулагчийн 6.2 сая төгрөгөөс 7 даатгуулагчийн 3.2 сая төгрөг буюу 51.6 хувийг барагдуулсан. Тэтгэмжийн даатгалын санд тавигдсан 11 даатгуулагчийн 3.4 сая төгрөгөөс 9 даатгуулагчийн 2.0 сая төгрөг буюу 83.3 хувийг тус тус барагдуулсан байна.	
2.3. Нийгмийн даатгалын багц хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах, хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн амаржсаны эмнэлгийн хуудсыг хянах ажлыг зохион байгуулах, тайлагнах;							
2.3.1	Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлыг зохион байгуулах, Иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь, хугацаа тогтоох үндэслэлийг хянах;		Зөвлөлийн хурлын явцад хяналт тавьсан байна. Иргэн (даатгуулагч)-ий өвчний түүх, амбулаторийн карт, үзлэг шинжилгээ, холбогдох бусад материал, цахим мэдээллийг хянасан байна.		Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлыг зохион байгуулах, Иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь, хугацаа тогтоох үндэслэлийг хянаж үйл ажиллагааг зохион байгуулсан байна.	2025 оны эхний хагас жилийн байдлаар ЭММЗөвлөл нь 22 удаа хуралдаж 735 иргэний асуудлыг хянан шийдвэрлэсэн ба ЭММЗөвлөлийн хурлын ирц 70-90 хувьтай хуралдсан байна. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгааныг шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад дотоодын хяналтыг хийж ижил мэргэжилтний үзлэгийг гэмтэл, дотор, мэдрэлийн чиглэлээр 3 удаа зохион байгуулсан бөгөөд ижил мэргэжилтний үзлэгээр гарсан алдаа зөрчилийг холбогдох эмч нартай уулзаж зөвөлгөө өгч ажиллаж байна.	90
2.3.2	Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;		Сургалт, сурталчилгаа хамтран зохион байгуулсан байна.		Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж үр дүнд хүрсэн байна. ХБИргэдийн асуудал шийдвэрлүүлэх тэдний үйл ажиллагаанд 2-с доошгүй удаа оролцсон байна.	Сумдын ХБИргэдийн холбоотой хамтран ажиллаж холбогдох мэдээ тайлан, зөвөлгөө зөвлөмж, ХЧАлдалттыг бууруулах, эмчлэн эрүүлжүүлэх, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар 3 удаагийн сургалтаар 440 иргэдэд мэдээлэл өгч ажилласан. 2025 оны 1 сарын 23 нд Баянхутаг сумын иргэдэд "Эмнэлгийн хуудас олгох бичих журам, иргэдийн үүрэг оролцоо" сэдвээр төрийн болон төрийн бус байгууллага иргэдэд сургалт зөвөлгөө өгч ажиллалаа. Сумын 3 эмч эмнэлгийн 4 мэргэжилтэн, иргэд гээд нийт 115 иргэд оролцлоо. Баянхутаг сумын засаг дарга	75

					Д.Байгалмаа болон удирдлагууд, ХБИргэдийн холбооны дарга Д.Алтанчимэг нартай уулзаж цаашид ажиллах төлөвлөгөө мөн ХБИргэдийг тогтвортой ажлын байраар хангаж ажиллуулах тал дээр онцгой анхаарч ажиллах, тохирсон хөдөлмөрийн нөхцөлийг анхаарах талаар төлөвлөгөөнд тусгах мөн эмчлэн эрүүлжүүлэх, намжмал үеийг уртасгах, рашаан сувилалын асуудлын талаар онцгой анхаарч ажиллахыг зөвөллөж хамтран ажиллахаар тохиролцсон. 2024 оны 2 сарын 13-нд Хэрлэн сумын соёлын төвд ХБИргэдийн уулзалт өдөрлөгт оролцож Хэрлэн сумын өрхийн 3 эмч тусгай мэргэжилтэн 2 болон 125 иргэдэд “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээлэл” сэдвээр сургалтыг хийж мөн 2024 оны Эрүүл мэндийн магадлалын тайланг танилцуулж, зөвөлгөө зөвлөмжүүдийг өгч ажилласан. Мөн 5 сард “Нийгэмд оролцоотой байя” хөгжлийн бэрхшээлтэй иргэний чуулганд оролцож 200 гаран иргэдэд мэдээлэл, зөвөлгөө өгч ажиллалаа.	
2.3.3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн чадварыг сэргээн засах, эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;		Орон нутгийн удирдлагуудтай хамтран зохион байгуулсан байна.	Эмчлэн эдгэрүүлэх төлөвлөгөө боловсруулж, Сэргээн засах тасгийн эмчтэй хамтран ажиллах, Физик эмчилгээнд илүүтэй хамруулан эмчилгээнд бариа заслаас гадна зүү төөнүүр, хөдөлгөөн засал, татлага эмчилгээний төрлүүдийг өмнөх жилүүдээс нэмэгдүүлж ажиллах иргэдийг уламжлалт эмнэлэгийн	Аймаг, сумын хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын байдлыг 2024 оны жилийн эцсийн тайланд үндэслэн нэгдсэн судалгааг өвчлөл төрөл бүрээр, /насжилт/-аар нь гаргаж дүн шинжилгээ хийж ажиллаа. Манай аймгийн нийт хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо 2731 буюу 2,9 хувьтай улсын дундажаас доогуур байна. Судалгаагаар Мөрөн, Баянадрага, Баянмөнх, Хэрлэн, Баяновоо, Бэрх сумдын хөдөлмөрийн чадвар алдалсан иргэдийн тоо улсын дундажаас өндөр 3,6-4,6 хувьтай байгаа тул орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад хөдөлмөрийн чадвар	60

					үзлэгт хамруулж ХЧАлдалттай иргэдийг 50 хүртэл хувийг хэвтэн эмчлүүлсэн байна.	алдалтыг бууруулах, эмчлэн эрүүлжүүлэх, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх тал дээр хамтран ажиллаж байна. Нэгдсэн эмнэлгийн сэргээн засах, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэгтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хэвтэн эмчлүүлэхэд дараалалгүй үйлчлэх боломжоор хангах тал дээр харилцан тохиролцож, сумдын ХБИргэдийн холбоотой хамтран ажиллаж холбогдох мэдээ тайлан, зөвөлгөө зөвлөмж, ХЧАлдалттыг бууруулах, эмчлэн эрүүлжүүлэх, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар 3 удаагийн сургалтаар 440 иргэдэд мэдээлэл өгч ажилласан.	
2.3.4	Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааг нийтэд сурталчлах, мэдээллийг нээлттэй, ил тод хүргэх арга хэмжээг зохион байгуулах; Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд судалгаа, шинжилгээ хийх;	Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдтэй хамтран зохион байгуулсан байна. Судалгааны программ арга, аргачлал ашиглан дүн шинжилгээ хийсэн байна.		Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааг нийтэд сурталчлах, мэдээллийг нээлттэй, ил тод хүргэх арга хэмжээг 2 удаа зохион байгуулж, Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд судалгаа, шинжилгээг бүтэн жилээр хийсэн байна.	Сумдын ХБИргэдийн холбоотой хамтран ажиллаж холбогдох мэдээ тайлан, зөвөлгөө зөвлөмж, ХЧАлдалттыг бууруулах, эмчлэн эрүүлжүүлэх, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар 3 удаагийн сургалтаар 440 иргэдэд мэдээлэл өгч ажилласан. 2025 оны 1 сарын 23 нд Баянхутаг сумын иргэдэд “Эмнэлгийн хуудас олгох бичих журам, иргэдийн үүрэг оролцоо” сэдвээр төрийн болон төрийн бус байгууллага иргэдэд сургалт зөвөлгөө өгч ажиллалаа. Сумын 3 эмч эмнэлгийн 4 мэргэжилтэн, иргэд гээд нийт 115 иргэд оролцлоо. Аймаг, сумын хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын байдлыг 2024 оны жилийн эцсийн тайланд үндэслэн нэгдсэн судалгааг өвчлөл төрөл бүрээр, /насжилт/-аар нь гаргаж дүн шинжилгээ хийж ажиллаа.	75	

						Манай аймгийн нийт хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо 2731 буюу 2,9 хувьтай улсын дундажаас доогуур байна. Судалгаагаар Мөрөн, Баянрага, Баянмөнх, Хэрлэн, Баяновоо, Бэрх сумдын хөдөлмөрийн чадвар алдалсан иргэдийн тоо улсын дундажаас өндөр 3,6-4,6 хувьтай байгаа тул орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, эмчлэн эрүүлжүүлэх, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх тал дээр хамтран ажиллаж байна.	
2.3.5	Эрүүл мэндийн байгууллагуудад иргэдийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн, амаржсаны эмнэлгийн хуудасны бичилт, зарцуулалтад хяналт тавих;		Иргэний амбулаторийн карт, өвчний түүх, эрүүл мэндийн анхан шатны баримт, цахим мэдээллийн санд үндэслэн шалгаж, холбогдох арга хэмжээг авч мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласан байна.		Эрүүл мэндийн байгууллагуудад иргэдийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн, амаржсаны эмнэлгийн хуудасны бичилт, зарцуулалтад хяналт тавьж, холбогдох арга хэмжээг авч мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласан байна.	“Даатгуулагч, иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт батлах тухай”, “Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам”-ын талаарх сургалтыг магадлагч эмч Д.Долгоржав, тэтгэмжийн байцаагч Б.Алтансүвд нар хамтран 2025 оны 02 дугаар сарын 5-14ны өдрүүдэд танхимаар болон цахимаар зохион байгуулсан. Сургалтанд нийт 70 эмч ажилчид хамрагдсан.	80
2.3.6	Иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалт, жирэмсэн амаржсаны болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэмжийн цахим хуудсыг хянах;		Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон шийдвэр, эрүүл мэндийн байгууллагын Эмнэлэг хяналтын комиссын шийдвэр, үйлдвэрлэлийн ослын акт зэрэгт тулгуурлан үндэслэлийг хянасан байна.		Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон шийдвэр, эрүүл мэндийн байгууллагын Эмнэлэг хяналтын комиссын шийдвэр, үйлдвэрлэлийн ослын акт зэрэгт тулгуурлан баталгаажуулан ажилласан байна.	Иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалт, жирэмсэн амаржсаны болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэмжийн цахим хуудсын хугацаанд нь хянан ажилласан. Үүнд: Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 1444, жирэмсэн, амаржсаны тэтгэмж 478 эмнэлгийн хуудасны бичилтэнд хяналт тавьж мэргэжил арга зүйн удирдлагаар хангасан.	90

2.4. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг хуулийн хугацаанд

ТОГТООЖ, ОЛГОХ, ОЛГОЛТОД ХЯНАЛТ ТАВИХ, МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ

2.4.1	Тэтгэврийн байцаагчийн шинээр тогтоосон тэтгэврийн үндэслэлийг шалгаж, тогтоолт, бодолтод хяналт тавих; Тэтгэврийн хувь, хэмжээг өөрчлүүлж буй тэтгэвэр авагчдын анхан шатны баримтын үндэслэл болон өөрчлөн бодолтыг хянах;		Тогтоосон тэтгэврийн үндэслэлийг шалгаж зөрчлийг арилгуулсан байна. Баримтын үндэслэлийг хянаж зөрчлийг арилгуулсан байна.		Тэтгэврийн байцаагчийн шинээр тогтоосон тэтгэврийн үндэслэлийг шалгаж, тогтоолт, бодолтод хяналт тавьж, Тэтгэврийн хувь, хэмжээг өөрчлүүлж буй тэтгэвэр авагчдын анхан шатны баримтын үндэслэл болон өөрчлөн бодолтыг хянаж баталгаажуулан ажилласан байна.	Шинээр 399 тэтгэвэр тогтоолгох хүсэлт хүлээн авч тэтгэврийн хувийн хэрэг нээж, дугаар өгч тэтгэвэр тогтоолгохоор бүрдүүлсэн баримт материалыг скайнардан мэдээллийн санд оруулж, сарын тэтгэврийн хэмжээг тогтоож, олгох асуудлыг хуулийн дагуу хугацаанд нь шийдвэрлэн даатгуулагчийн тэтгэврийн тогтоолтын хуудсыг хэвлэж, баталгаажуулан хувийн хэрэгт хавсарган ажилласан. Тогтоосон тэтгэврийн үндэслэлийг шалгаж 23 тэтгэвэр тогтоолтийг буцааж материалын үндэслэлийг бүрлүүлж зөрчлийг арилгуулсан байна.	90
2.4.2	Даатгуулагчийн хүсэлтийг үндэслэн жирэмсний, амаржсаны болон хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, Нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмжийн бодолт, олголтын тооцоог нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сантай тулган хянах;		Тэтгэмжийг хянан баталгаажуулсан байна.		Даатгуулагчийн хүсэлтийг үндэслэн жирэмсний, амаржсаны болон хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, Нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмжийн бодолт, олголтын тооцоог нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сантай тулган хянаж зөрчил дутагдал арилгаж ажилласан байна.	Тайлант хугацаанд тэтгэмжийн даатгалын сангаас 1138 даатгуулагчдын тэтгэмжийн бодолт, олголтын тооцоог нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сантай тулган хянаж ажилласан ба үүнээс хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 652 даатгуулагчид, жирэмсэн болон амаржсаны тэтгэмж 337 даатгуулагчид, 149 даатгуулагчийн Нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмжийг тус тус хянасан байна. Нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмжийн эрх үүсээгүй 1 даатгуулагчтай холбоотой зөрчилийг илрүүлж арилгасан.	85
2.4.3	Ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт ирүүлсэн даатгуулагчийн тэтгэмж авах эрх цалингийн үндэслэлийг хянах;		Тэтгэмжийг хянан баталгаажуулсан байна.		Ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт ирүүлсэн даатгуулагчийн тэтгэмж авах эрх цалингийн үндэслэлийг хянаж баталгаажуулан зөрчил арилган ажилласан байна.	Ажилгүйдлийн даатгалын сангаас 391 даатгуулагчдад олгож байгаа тэтгэмжийн олголтонд хяналт тавьж ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаанд ажилд орж, албан журмаар шимтгэл төлж эхэлсэн даатгуулагчтай холбогдож ажилд орсон тушаалыг авч 13 даатгуулагчтай холбоотой	85

					тэтгэмжийг зогсоож тухайн даатгуулагчтай тооцоо нийлж тэтгэмжийн хувийн хэрэгт тэмдэглэгээ хийж илүү олгосон тэтгэмжийг улсын байцаагчийн актаар төлүүлэх арга хэмжээ авч ажилсан.	
2.4.4	Тэтгэвэр, тэтгэмж, ҮОМШӨ-ний даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалтад хийх хяналт шалгалтыг тогтмол чанартай зохион байгуулж, үр дүнг тооцох;		Хяналт шалгалтын үр дүн дээшилсэн байна.		Тэтгэвэр, тэтгэмж, ҮОМШӨ-ний даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалтад хийх хяналт шалгалтыг тогтмол чанартай зохион байгуулж, үр дүнг тооцон зөрчил арилгах арга хэмжээ авч ажилласан байна.	90
2.4.5	Тэтгэвэр авагчдын хувийн хэрэг, хавсаргасан баримтыг тэтгэвэр авагчдын жагсаалттай тулган жилд 2 удаа тооллого явуулах, тэтгэврийн хувийн хэрэг дутсан тохиолдолд шалтгааныг тодруулан нөхөн бүрдүүлэх;		Тооллого шалгалтыг хийж, холбогдох арга хэмжээ авч ажилласан байна.		Тэтгэвэр авагчдын хувийн хэрэг, хавсаргасан баримтыг тэтгэвэр авагчдын жагсаалттай тулган жилд 2 удаа тооллого явуулах, тэтгэврийн хувийн хэрэг дутсан тохиолдолд шалтгааныг тодруулан нөхөн бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, тооллого хийсэн материалыг хадгаламжийн нэгж болгон архивт хүлээлгэн өгсөн байна.	60
2.4.6	Мэргэжлийн болон хөндлөнгийн хяналтын байгууллагын шалгалтад хамрагдах, Улсын байцаагчийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлэх		Улсын байцаагчийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна.		Мэргэжлийн болон хөндлөнгийн хяналтын байгууллагын шалгалтад хамрагдаж, Улсын байцаагчийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хугацаанд	Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тухай бүр тооцон тайлан, мэдээг хугацаанд нь Захиргаа

	арга хэмжээ авах.				нь хэрэгжүүлэх арга хэмжээ авах ажлыг зохион байгуулан үүрэг даалгаврыг биелүүлэн ажилласан байна.	Хяналтын хэлтэст хүргүүлэн ажиллаж байна. 2025 оны хагас жилийн байдлаар дээд шатны болон хяналтын бусад байгууллагаас хийсэн шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн оны эхний үлдэгдэл 70.1 сая төгрөгөөс 21% буюу 14.5 сая төгрөгийг барагдуулан 55.6 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс 2 тэтгэвэр авагчийн тэтгэврийн олголтыг зогсоож 43.9 сая төгрөгийг барагдуулахаар уулзалт зохион байгуулан, хэвийн өндөр насны тэтгэвэр тогтоогдож байгаа 1 хүний тэтгэврээс суутгал хийж барагдуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	60
--	-------------------	--	--	--	--	--	----

Биелэлт 2315/27 85,74%

Гурав. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.

3.1. Байгууллагын болон нэгжийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх, тайлагнах.

3.1.1	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар тогтоосон төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, ёс зүйн нийтлэг шаардлага болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг сахин мөрдөж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хууль болон үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, дүн шинжилгээ хийх ажлыг нэгжийн хэмжээнд зохион байгуулах;		Хууль, дүрэм журам хэрэгжсэн, мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан байна.	2 удаа сургалтанд хамруулсан	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар тогтоосон төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, ёс зүйн нийтлэг шаардлага болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг сахин мөрдөж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хууль болон үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулан ажиллах	2025.05.08-нд “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, орон нутагт ажиллаж амьдрах эрхийн баталгааг хангахад анхаарах асуудлыг тодорхойлох” сэдэвт сургалтыг хууль зүйн доктор, профессор Б.Өлзийсайхан 23 байцаагч хамрагдсан. 2025.05.15-нд “Төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх,” сэдэвт сургалтыг хууль зүйн доктор, профессор Б.Өлзийсайхан 25 байцаагч хамрагдсан.	100
3.1.2	Хэлтсийн албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх		Авлигаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулсан байна.	Хэлтсийн ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон	Хэлтсийн албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг	Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 1 удаа зохион	

				хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах.	дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.	байгуулж НДЕГазар болон АЗДТГазраас зохион байгуулж байгаа "Нэг цаг, нэмэх цэнэг" сургалтанд цахимаар 2 удаа хамрагдаж нийт 46 албан хаагч хамрагдсан. "Стресс менежмент" сэдвийн хүрээнд сургагч багш М.Гэрлээ 2025.04.10-нд 23 байцаагч, "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, орон нутагт ажиллаж амьдрах эрхийн баталгааг хангахад анхаарах асуудлыг тодорхойлох" сэдэвт сургалт 2025.05.15-нд 23 байцаагч хамрагдсан. НДЕГазрын ЭММТЗөвлөлөөс, АТГ Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран Авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийн талаарх ээлжит сургалтанд 2025-05-28-нд цахимаар хамрагдсан.	80
3.1.3	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;		Өргөдөл, санал, гомдлыг хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь шийдвэрлэсэн байна.		Өргөдөл, санал, гомдлыг хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь шийдвэрлэсэн байна.	Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс ирүүлсэн Ажилгүйдлийн тэтгэмж орохгүй байгаа тухай иргэдийн 11 өргөдөл гомдолд хугацаанд нь хариу өгч ажилласан. Тайлант хугацаанд тэтгэвэр авагчидаас нийт 4 өргөдөл буюу тэтгэвэр өөрчлөн тогтоолгохтой холбоотой хүсэлтийг авч тухай бүр шийдэж ажилласан.	95

Биелэлт 275/3 91,6%

Нийт биелэлт 262,34 /3 87,4 %

